



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГУУД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН
ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

АУДИТЫН НЭР : ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН
АУДИТЫН КОД: АРА-2025/21ШТА-НА



Цэцэрлэг хот 2025 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatar@audit.gov.mn

Ахлах аудитор П.Цэцэгдулам

Утас: 7033-3019 Цахим хаяг: tsetsegdulamp@audit.gov.mn

Аудитор В.Цогжаргал

Цахим хаяг: tsogjargalb@audit.gov.mn

Аудитор Б.Анхтуяа

Цахим хаяг: ankhtuyalbo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: Open.audit.mn

2



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</i>
МУЕА	<i>Монгол Улсын Ерөнхий аудитор</i>
ШТА	<i>Шууд тайлагнах аудит</i>
АДБОУС	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</i>
ТБОНӨХЭ	<i>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд</i>
ТЕЗ	<i>Төсвийн ерөнхийлөн захирагч</i>
БГАУТХ	<i>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</i>

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төрийн хэмнэлтийн хуулийн 4-12 дугаар зүйлийн хамаарал бүхий заалт	6
Хүснэгт 2	Төрийн хэмнэлтийн хуулийн 4-12 дугаар зүйлийн зөрчлийн нэгтгэл	6-7
Хүснэгт 3	Хуулийн 15.1 дэх хэсэгтэй холбоотой зөрчил	9
Хүснэгт 4	Хуулийн 15.2 дахь хэсэгтэй холбоотой зөрчил	10
Хүснэгт 5	Худалдан авах ажиллагааны судалгаа	12
Хүснэгт 6	Хэмнэлт зардлын ангиллаар	15-16
Хүснэгт 7	Мэдээлэл байршуулалтын судалгаа	24

График, дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	2022-2024 оны нийт зөрчил	8
График 2	Шийдвэрийн ангилал (мянган төгрөг)	9
Дүрслэл 1	Зардлын ангиллаар	10
График 3	2022-2024 оны хэмнэлт	16
График 4	Шийдвэр судалгаа	18



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ-т, аймгийн Засаг дарга, ИТХ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх
- Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан эсэх
- Төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн Засаг дарга, тэдгээрийн харьяа байгууллагууд, зарим ТӨҮГ, ОНӨААТҮГ-ын 2022, 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил болон түүнтэй уялдуулан 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитн арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах баримт материал, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, түүвэрлэлт хийж, нэгдсэн судалгааны маягтын дагуу үр дүнг нэгтгэн тайлагналаа.

Үндсэн мэдээлэл:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зорилт нь төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ хуулийг УИХ-аас 2022 онд баталсан бөгөөд 4 бүлэг 22 зүйл, 108 заалттай, Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2022 онд 1 удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 3 удаа тус тус нэмэлт өөрчлөлт орсон.



Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд жил бүр санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд 2022, 2023 онуудад дараах зөрчилтэй асуудлууд илэрч байжээ. Үүнд:

- 2022 онд нийт 37 байгууллагатай холбоотой 222.1 сая төгрөгийн зөрчил илэрсний 14.9 сая төгрөг буюу 6.7 хувь нь хуулиар зөвшөөрөөгүй бусад зардал, 81.7 хувь нь албан томилолтын зардал, чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоосон болон хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгосонтой холбоотой зөрчлүүд
- 2023 онд нийт 7 байгууллагатай холбоотой 47.7 сая төгрөгийн зөрчил илэрсний 29.9 хувь нь хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгосон, 20.7 хувь нь хуулийн нөөцлөх шаардлагагүй бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцөлсөн, 1.3 хувь нь хуулиар зөвшөөрөөгүй бусад зардал, 48.2 хувь нь тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгож, томилсон болон Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийх энэхүү аудитад 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг үнэлж ОНӨААТҮГ-5, ТӨХК-1, орон нутгийн төсвийн-32, Улсын төсвийн буюу босоо төсөвтэй-3, боловсрол, соёлын салбарын-34, эрүүл мэндийн салбарын-11, нийт 86 байгууллагын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд түүвэрлэн хяналтыг хэрэгжүүллээ. Үүнээс хязгаарлалттай санал дүгнэлт авсан 32 байгууллага байна.



БҮЛЭГ 1. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-12 дугаар зүйлийн заалтуудыг шалгадагч байгууллагууд бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйл буюу үйлчлэх хүрээнд 3.1.1-3.1.11-т заасан хуулийн этгээд, албан тушаалтан, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр хамаарахаар заасан байна. Тус хуулийн 4-12 дугаар зүйлийн тухайд нийт 30 заалттай бөгөөд үүний 83.3 хувь буюу 25 заалт нь орон нутагт хамаарал бүхий заалт байна.

Хүснэгт№1 Төрийн хэмнэлтийн хуулийн 4-12 дугаар зүйлийн хамаарал бүхий заалт

(мянган төгрөг)

Зүйл	Зүйлийн нэр	Нийт заалтын тоо	Орон нутагт хамааралтай	
			Тийм	Үгүй
4 дүгээр зүйл	Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим	10	10	0
5 дугаар зүйл	Тэргүүн дэд, дэд, орлогч дарга	4	3	1
6 дугаар зүйл	Тээврийн хэрэгсэл	4	4	0
8 дугаар зүйл	Дүрэмт хувцас	2	1	1
9 дүгээр зүйл	Албан томилолт	3	1	2
10 дугаар зүйл	Цалин хөлс, нэмэгдэл	2	2	0
11 дүгээр зүйл	Нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1	1	0
12 дугаар зүйл	Бусад хангамж	4	3	1
дүн		30	25	5

Эх сурвалж: Төрийн хэмнэлтийн тухай хууль

Төрийн аудитын газрын 2022-2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар хуулийн 4-12 дугаар зүйлд тусгасан орон нутагт хамаарал бүхий заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс нийт 61 байгууллагатай холбоотой 343,830.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас 27 байгууллагад 81,173.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 29 байгууллагад 242,728.9 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, 1 байгууллагад хариуцлага тооцуулах албан шаардлага, 4 байгууллагад 19,928.2 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж 2022, 2023 оны шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулан ажилласан бол 2024 оны 181,782.3 мянган төгрөгийн 25 шийдвэрийн биелэлтийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт№2 Төрийн хэмнэлтийн хуулийн 4-12 дугаар зүйлийн зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Хуулийн заалт	2022 он		2023 он		2024 он	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
4 дүгээр зүйл: Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг хэрэгжүүлж ажилласан эсэх	6	57,798.9	15	89,636.9	21	173,501.5
5 дугаар зүйл: Тэргүүн дэд, дэд, орлогч дарга ажиллуулсан эсэх	1	-	0	-	0	-
6 дугаар зүйл: Тээврийн хэрэгслийн хязгаарлалтыг хэрэгжүүлж ажилласан эсэх	0	-	2	-	0	-
8 дугаар зүйл: Дүрэмт хувцасны хязгаарлалтыг хэрэгжүүлсэн эсэх	2	4,206.6	0	-	4	8,280.8
9 дүгээр зүйл: Албан томилолтын зардлыг хязгаарласан эсэх	4	7,214.7	0	-	0	-



10 дугаар зүйл: Цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоосон эсэх	0	-	0	-	0	-
11 дүгээр зүйл: Нэг удаагийн тэтгэмж давхардуулан олгосон эсэх	0	-	0	-	0	-
12 дугаар зүйл: Бусад хангамжийн зардлыг хэмнэсэн эсэх	2	2,490.0	4	700.7	0	-
Дүн	15	71,710.2	21	90,337.6	25	181,782.3

Төсөв захирагчдын 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар хуулийн 4-12 дугаар зүйлийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэнд холбогдох шийдвэрийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулаад байна. Үүнд:

- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим” буюу 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.6-т “сахилга баттай байх”, 4.1.9-т “хариуцлагатай байх” гэсэн зарчмуудыг баримталж ажиллаагүйгээс 42 байгууллагатай холбоотой нийт 320,937.3 мянган төгрөгийн зөрчил илэрч аудитаас 17 байгууллагад 68,002.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 23 байгууллагад 233,090.2 мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 2 байгууллагад 19,844.2 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна. Илэрсэн зөрчлөөс харахад хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах
- ✓ Хуулийн 5 дугаар зүйл “Тэргүүн дэд, дэд, орлогч дарга” буюу 5.2-т “Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй 1 байгууллагад албан шаардлага хүргүүлсэн байна. Үүний үр дүнд аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Б/32 дугаар захирамжаар Засаг даргын 1 орлогчийг, аймгийн Засаг даргын тамгын даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/144, Б/145 дугаар тушаалаар 2 зөвлөхийг ажлаас нь чөлөөлж цалингийн зардлын хэмнэлтийг бий болгож, чиг үүргийн давхардлыг арилгасан бөгөөд 2023-2024 онуудад тухайн зөрчил давтагдан гараагүй бөгөөд аймаг, сумдын засаг дарга нь зөвхөн нэг орлогч даргатай ажиллаж байна.
- ✓ Хуулийн 6 дугаар зүйл “Тээврийн хэрэгсэл” буюу 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэсэн заалтыг зөрчсөн 2 байгууллагад 2022 онд албан шаардлага хүргүүлж зөрчлийг таслан зогсоосон байна. Харин 2023-2024 онд тээврийн хэрэгсэлтэй холбоотой зөрчил илрээгүй бөгөөд байгууллагад бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болсон байна.
- ✓ Хуулийн 8 дугаар зүйл “Дүрэмт хувцас”-ны 8.1-т “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс нийт 6 байгууллагатай холбоотой 12,487.4 мянган төгрөгийн зөрчил илэрч аудитаас 5 байгууллагад 9,705.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 байгууллагад 2,782.0 мянган төгрөгийн зөрчил арилгуулах


албан шаардлага хүргүүлсэн байна.

- ✓ Хуулийн 9 дүгээр зүйл “Албан томилолт” буюу 9.3-т “Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс нийт 4 байгууллагатай холбоотой 7,214.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 3 байгууллагад 2,794.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 байгууллагад 4,420.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлсэн байна.
- ✓ Хуулийн 10 дугаар зүйл буюу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой зөрчил гараагүй байна.
- ✓ Хуулийн 11 дүгээр зүйл “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж”-тэй холбоотой заалтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд үүнтэй холбоотой зөрчил гараагүй байна.
- ✓ Хуулийн 12 дугаар зүйл “Бусад хангамж” буюу 12.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс нийт 6 байгууллагатай холбоотой 3,190.7 мянган төгрөгийн зөрчил илэрч 2 байгууллагад 670.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2 байгууллагад 2,436.7 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, 1 байгууллагад хариуцлага тооцуулах албан шаардлага, 1 байгууллагад 84.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна. Үүний 83.3 хувь нь хуулийн 12.1.1, 12.1.4 дэх заалтыг зөрчсөнтэй холбоотой байна.

ТХТХ- зөрчсөнтэй холбоотой аудитаар илэрсэн нийт зөрчлийг графикаар харуулбал:

График №1 2022-2024 оны нийт зөрчил

(мянган төгрөг)



Графикаас харахад хуулийн 4-12 дугаар зүйлийг хэрэгжүүлэн ажиллаагүйтэй холбоотой 2022-2024 онд илэрсэн нийт зөрчлийн тоо болон мөнгөн дүн өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Энэ нь байгууллагуудын төсөв, санхүү жилээс жилд өсөхийн хэрээр зөрчлийн тоо мөнгөн дүн өсөж байгаа боловч нөгөө талаар төсвийн үр ашиггүй, хэмнэлтгүй, сахилга батгүй, үрэлгэн зарцуулалт нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Иймээс төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсөв санхүүгийн сахилга батгүй, хариуцлагагүй, хэмнэлтгүй зарцуулалт, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлахад чиглэсэн шат шатны дотоод хяналтын тогтолцоог сайжруулж, хэмнэлтийг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй байна.




1.2 Байгууллагууд хэмнэлтийн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч хуулийн 15.1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх хэмнэлтийн бусад арга хэмжээний талаар тусгасан.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан хориглох заалтын тухайд:

График №2 Шийдвэрийн ангилал (мянган төгрөг)



Хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу өнгөрсөн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар хуулийн 15.1-д заасан хориглох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой нийт 60 төсвийн байгууллага, 2 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд 622,463.8 мянган төгрөгийн зөрчил илэрч 50,602.8 мянган төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 571,861.0 мянган төгрөгийн зөрчилд 72 албан шаардлага хүргүүлэн биелэлтийг фас системээр үнэлж ажилласан байна. 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийн хугацаа болоогүй байна.

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох, 15.1.5 “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” заалтуудыг зөрчсөн 8,246.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага;
- ✓ Хуулийн 15 дугаар зүйл буюу хэмнэлтийн бусад арга хэмжээг авч ажиллах талаар аймгийн ЕБС-ийн захирал нарт 24 зөвлөмж хүргүүллээ.

Хуулийн 15.1 дэх заалттай холбоотой нийт илрүүлэлтийн 92.5 хувь нь төсвийн байгууллагад, 7.5 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд илэрсэн зөрчил байна. Илрүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 Хуулийн 15.1 дэх хэсэгтэй холбоотой зөрчил

(мянган төгрөг)

Заалтын утга	2022 он	2023 он	2024 он	Нийт дүн
15.1.2 Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох	27,625.3	54,641.2	-	82,266.5
15.1.3 Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох	61,675.8	238,376.4	129,775.3	429,827.5
15.1.4 Нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх	12,370.0	-	-	12,370.0
15.1.5 Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах	16,812.4	3,461.9	38,767.0	59,041.3
15.1.6 Шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх	6,000.0	-	41,204.8	47,204.8
Дүн	124,483.5	296,479.5	209,747.1	630,710.1

Хүснэгтээс харахад нийт зөрчлийн 68.1 хувь нь хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгосон, 13.0 хувь нь чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоосон зөрчил дийлэх хувийг эзэлж байна.

Үүнийг заалт тус бүрээр дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна.

- ✓ 15.1.2 дахь заалтын хүрээнд 4 төсвийн байгууллагад 82,266.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага,
- ✓ 15.1.3 дахь заалтын хүрээнд 49 төсвийн байгууллагад 422,893.0 мянга, 1 ТБОНӨХЭ-д 6,934.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 28,294.2 мянган төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт, 401,533.3 мянган төгрөгийн зөрчилд 51 албан шаардлага,
- ✓ 15.1.4 дэх заалтын хүрээнд 2 төсвийн байгууллагад 12,370 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага,
- ✓ 15.1.5 дахь заалтын хүрээнд 13 төсвийн байгууллагад 43,898.5 мянга, 2 ТБОНӨХЭ-д 15,142.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 14 албан шаардлага
- ✓ 15.1.6 дахь заалтын хүрээнд 3 төсвийн байгууллагад 22,308.6 мянга, 1 ТБОНӨХЭ-д 24,896.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 12,308.6 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 24,896.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.
- ✓ Хуулийн 15 дугаар зүйл буюу хэмнэлтийн бусад арга хэмжээг авч ажиллах талаар аймгийн ЕБС-ийн захирал нарт 24 зөвлөмж хүргүүлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглох заалтын хүрээнд төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нийт 1,134,610.5 мянган төгрөгийг хэмнэж ажиллажээ. Хэмнэлтийг зардлын ангилал болон хуулийн заалттай уялдуулан үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл №1 Зардлын ангиллаар
(мянган төгрөг)



Хуулийн 15.1.3 дахь заалтын дагуу урсгал шилжүүлгийн зардлаас 44 байгууллага 137,110.4 мянган төгрөг;

Хуулийн 15.1.5 дахь заалтын дагуу БГАҮТХ-ийн зардлаас 3 байгууллага 2,348.9 мянга, бараа үйлчилгээний зардлаас 2 байгууллага 10,052.5 мянган төгрөг;

Хуулийн 15.1.6 дахь заалтын дагуу хангамж, бараа материалын зардлаас 49 байгууллага 59,093.3 мянга, эд хогшил урсгал засварын зардлаас 29 байгууллага 87,076.9 мянга, БГАҮТХ-ийн зардлаас 38 байгууллага 282,564.9 мянга, бараа үйлчилгээний зардлаас 22 байгууллага 556,363.6 мянган төгрөгийг тус тус хэмнэж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.



Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтын тухайд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасны дагуу төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хэмнэлтийн дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- ✓ 15.2.1 “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” заалтын хүрээнд нийт 209 байгууллага 2,278,271.2 мянган төгрөгийн тогтмол зардлыг;
- ✓ 15.2.4 “Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх” заалтын хүрээнд 21 байгууллага 29,392.2 мянган төгрөгийн хангамж бараа материалын зардлыг;
- ✓ 15.2.6 “Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” заалтын хүрээнд 118 байгууллага 1,826,659.8 мянган төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг хэмнэж орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Өмнөх аудитаар хуулийн 15.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

Хүснэгт №4 Хуулийн 15.2 дахь хэсэгтэй холбоотой зөрчил

Заалтын утга	2022 он	2023 он	2024 он	Нийт дүн
15.2.3 Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх	46,580.3	-	-	46,580.3
15.2.5. Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;	8,523.3	71,749.0	665,347.5	745,619.8
15.2.6.Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох	395.8	16,700.0	39,485.7	56,581.5
Дүн	55,499.4	88,449.0	704,833.2	848,781.6

Хүснэгтээс харахад нийт зөрчлийн 87.8 хувь нь өр төлбөртэй холбоотой зөрчил эзэлж байна. Зөрчлийг заалт тус бүрээр дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна.

- ✓ Хуулийн 15.2.3 дахь заалтын хүрээнд 6 төсвийн байгууллагад 46,580.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,329.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 45,251.3 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага;
- ✓ 15.2.5 дахь заалтын хүрээнд 1 төсвийн байгууллага, 4 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд 745,619.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 680,168.4 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 65,451.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж;



- ✓ 15.2.6 дахь заалтын хүрээнд 16 төсвийн байгууллагад 56,581.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 52,445.8 мянган төгрөгийн зөрчилд 16 төлбөрийн акт, 4,135.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.

Харин хуулийн 15.2.2-т “Нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах” гэсэн заалт нь хэрэгжээгүй байна. Иймд нэгдсэн бодлого, арга зүйгээр хангаж хэрэгжилтийг хангуулах нь зүйтэй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон байна.

Төсвийн байгууллагын тухайд хуулийн 15.1.3¹, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тухайд 15.2.5² дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчил нийтлэг байна. Иймд байгууллагууд шагнал, тэтгэмж урамшууллыг хуулийн дагуу олгох, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА

2.1 Хуулийн 13 дугаар зүйлд заасан “Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ”-ний 13.3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл нь 7 хэсэг, 16 заалттай бөгөөд 13.1.1, 13.1.2 дахь заалтууд нь 2025 оноос эхлэн хэрэгжиж байна.

Хуулийн 13 дугаар зүйлд улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд тусгахыг хориглосон зүйлсийн жагсаалт болон хэрэгжилтийг зохион байгуулахад баримтлах журмын талаар тусгасан байдаг.

Аймгийн хэмжээнд 2022, 2023 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 73,132,940.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 135 төсөл, арга хэмжээ батлагдсанаас худалдан авах ажиллагааны үр дүнд 6,481,477.8 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож улсын төсөвт 6,051,900.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 429,577.8 мянган төгрөгийг төвлөрүүлжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №5 Худалдан авах ажиллагааны судалгаа

(мянган төгрөг)

Он	Төрөл	ТАХ-ний тоо	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэмнэлт	Улс, орон нутгийн төсөвт
----	-------	-------------	-------------------------	--------------	---------	--------------------------

¹ Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох

² Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх



						төвлөрүүлсэн дүн
2023	УТХО	1	500,000.0	498,200.0	1,800.0	1,800.0
	ОНТХО	56	2,553,000.0	2,422,100.0	130,900.0	130,900.0
2024	УТХО	28	65,307,600.0	59,257,500.0	6,050,100.0	6,050,100.0
	ОНТХО	50	4,772,340.2	4,473,662.4	298,677.8	298,677.8
НИЙТ ДҮН		135	73,132,940.2	66,651,462.4	6,481,477.8	6,481,477.8

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой дараах зөрчлүүд илэрч байжээ. Үүнд:

- ✓ Хуулийн 13.1 “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална” гэсний 13.1.3 “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” заалтыг зөрчиж 2024 онд 8,114.2 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны хэмнэлтийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт;
- ✓ 13.1.5 “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх” заалтыг зөрчиж 2024 онд төсөвт өртгийг 1,513.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, зарцуулсан зөрчилд төлбөрийн акт;
- ✓ Хуулийн 13.3 “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно” гэсний 13.3.3 “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” заалтыг зөрчиж дээрх шаардлагыг хангаагүй ТАХ-г баталж хэрэгжүүлсэнтэй холбоотой 2023 онд 141,900.0 мянган төгрөгийн зөрчилд аймгийн ИТХ болон 3 сумын ИТХ, Засаг даргад 7 албан шаардлага, 2024 онд 837,429.1 мянган төгрөгийн зөрчилд 5 сумын ИТХ, Засаг даргад 10 албан шаардлага тус тус хүргүүлж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн зөрчил жил бүр давтагдан гарсаар байна. Иймд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлтэй холбоотой зөрчил давтагдан гарсан тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог хуульд нарийвчлан тусгах нь зүйтэй байна.

2.2 Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүй байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд төсвийн байгууллагууд тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс хэрхэн худалдан авах талаар тусгасан байдаг. Гэтэл төсвийн



байгууллагуудад энэхүү заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. *Тухайлбал:* 2024 онд Ерөнхий боловсролын сургуулиуд нь нийт 814,595.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсний 18 хувь буюу 148,989.0 мянган төгрөгийн хөрөнгийг л цахим дэлгүүрээс худалдан авсан байна. Өөрөөр хэлбэл үлдэх 82 хувь буюу 671,695.1 мянган төгрөгийн хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй, хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, тендер зохион байгуулаагүй 1,154,969.0 мянган төгрөгийн зөрчилд 2024 оны СТА-аар зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй шалтгааныг тодруулахад дараах тайлбарыг өгч байлаа.

- Цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр худалдан авч буй барааны жагсаалтад шаардлагатай тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бараа материал байдаггүй.
- Худалдан авах бараа, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх хүсэлтийг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлдэг боловч тухай бүр холбогдох бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт оруулдаггүй,
- Цахим дэлгүүрийн барааны үнэ зах зээлийн үнээс өндөр,
- Материалын хувьд чанар стандартын шаардлага хангадаггүй зэрэгтэй холбоотой байна.

БҮЛЭГ 3. ХУУЛИЙН ДАГУУ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДААС АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАСАН БАЙНА

3.1 Хуульд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хянал тавьж ажиллана” гэж заасан байна.

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын хяналтын байгууллагаас Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргээ эсэхийг орон нутагт шалгаж дүгнэх боломжгүй байна.

Төрийн аудитын байгууллагын тухайд МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан.

Энэхүү заавар чиглэлийн хүрээнд аймаг дахь төрийн аудитын газар нь санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудиттай хослуулан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж 2022-2024 онд нийт 2,804,032.6 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж 195,178.6 мянган төгрөгийн зөрчилд 58 төлбөрийн акт тогтоож, 2,523,474.5 мянган төгрөгт зөрчил арилгуулах 307, хариуцлага тооцуулах



9 албан шаардлага, 85,379.5 мянган төгрөгийн 42 зөвлөмжийг хүргүүлж шийдвэрийн хэрэгжилтийг хангуулаад байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн бусад арга хэмжээг хэрэгжүүлэх талаар аймгийн ТЕЗ-аас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн заавар чиглэл, зөвлөмж хүргүүлжээ.Үүнд:

- ✓ Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 02/44 тоот албан бичгээр "Төсвийн сахилга хариуцлагыг чангатгаж, хэмнэлтийн горимоор ажиллах зарим арга хэмжээний тухай"
- ✓ Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/318 тоот "Үүрэг чиглэл өгөх тухай" албан бичиг
- ✓ Аймгийн Засаг даргын 2024 оны А/73 дугаар захирамжаар баталсан "Сумдын санхүү, алба, төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх" төлөвлөгөөний дагуу хяналт хийж аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/1546 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2 Хуулийг мөрдөж ажилласнаар 7,401,579.2 мянган төгрөгийг хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлээс үзэхэд орон нутгийн төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардлаас 2023 онд 2,544,125.5 мянган төгрөг, 2024 онд 4,857,453.7 мянган төгрөг хэмнэгдсэн байна. Хэмнэлтийг зардлын ангиллаар нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт№6 Хэмнэлт зардлын ангиллаар							(мянган төгрөг)
Хэмнэгдсэн зардал	2023 он	2024 он	Нийт	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалт			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
Цалин, Шимтгэл	43	529,567.3	75	1,297,092.5	118	1,826,659.8	15.2.6.байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101	802,370.3	108	1,475,900.9	209	2,278,271.2	15.2.1.байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;
Хангамж, бараа материалын зардал	28	29,815.0	21	29,278.3	49	59,093.3	15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;
	1	113.9	20	29,278.3	21	29,392.2	15.2.4.бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх;
Нормативт зардал	1	2,087.0	2	42.8	3	2,129.8	8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.
Эд хогшил, урсгал засварын зардал	6	13,164.7	23	73,912.2	29	87,076.9	15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр



							бараа, материал бэлтгэх, нөөцлөх;
Томилолт, зочны зардал	12	16,494.7	25	11,804.6	37	28,299.3	9.3.Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2	2,928.0	19	247,292.4	21	250,220.4	12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад.
	11	331,252.1			11	331,252.1	13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;
	3	2,348.9			3	2,348.9	15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;
	18	35,272.5	20	247,292.4	38	282,564.9	15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;
Бараа үйлчилгээний бусад зардал	1	51,085.4	15	327,057.3	16	378,142.7	12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад.
	5	218,808.1			5	218,808.1	13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;
	2	10,052.5			2	10,052.5	15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;
	7	35,905.8	15	327,057.2	22	362,963.0	15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;
Урсгал шилжүүлэг	2	27,500.0	8	61,566.2	10	89,066.2	12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад.
	2	38,809.8	3	31,965.0	5	70,774.8	11.1.Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй.
	4	31,288.0	40	105,822.4	44	137,110.4	15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;
Хөрөнгийн зардал	1	4,180.0			1	4,180.0	12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад.
	5	361,081.4	7	592,091.2	12	953,172.6	13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;
Нийт		2,544,125.4		4,857,453.7	656	7,401,579.2	

Хүснэгтээс харахад хамгийн их хэмнэгдсэн зардлыг нийт хэмнэлттэй харьцуулж, хуулийн заалттай нь нийцүүлэн авч үзвэл дараах байдалтай байна: Тухайлбал:

- ✓ Хуулийн 15.2.1-д “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэсэн заалтын хүрээнд байр ашиглалттай холбоотой



- тогтмол зардлаас 2,278,271.2 мянган төгрөг буюу 30.8 хувь,
- ✓ Хуулийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтын хүрээнд байгууллагын цалин, шимтгэлийн зардлаас 1,826,659.8 мянган төгрөг буюу 24.7 хувь,
 - ✓ Хуулийн 13.1.4-т “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх” гэсэн заалтын дагуу хөрөнгийн зардлаас 957,352.6 мянган төгрөг буюу 13.0 хувь,
 - ✓ Хуулийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтын хүрээнд бусад зардлаас 985,098.7 мянган төгрөг буюу 13.3 хувийг тус тус эзэлж байна.

График №3 2022-2024 оны хэмнэлт (сая. төг)



Харин нийт хэмнэлтийг аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 2023 онд нийт төсвийн 3.9 хувь, 2024 онд 5.7 хувь нь хэмнэгдсэн байна.

Дээрх байдлаас үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллан 2023-2024 оны нийт батлагдсан төсвийн 4.9 хувийн хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.3 Шилэн дансны мэдээлэл байршуулалт 93.5 хувьтай байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэж, мөн Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд байгууллагуудын <https://shilendans.gov.mn/> системийн хөтлөлтөд хяналт тавихад 2022-2024 оны байдлаар нийт мэдээлбэл зохих 38840 мэдээллээс 36340 мэдээллийг хугацаанд нь, 1700 мэдээллийг хугацаа хоцроосон, 974 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №7 Мэдээлэл байршуулалтын судалгаа

Шилэн дансны цахим системд мэдээлсэн байдал				
Он	Мэдээлбэл зохих	Үүнээс:		
		Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Мэдээлээгүй

2022	12986	11893	1039	90
2023	11613	10346	434	831
2024	14241	14101	227	53
Нийт дүн	38840	36340	1700	974
Хувь		93.5	4.4	2.5

Хүснэгтээс харахад Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг нийт хамрагдсан байгууллагууд **93.5** хувьтай мэдээлсэн ба хугацаа хоцроосон, мэдээлээгүй мэдээллийн тоо буурсан байна.

График №4 Шийдвэр судалгаа



Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон, огт мэдээлээгүй зөрчилд 2022-2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 35 зөвлөмж, 177 албан шаардлага, 8 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг хангуулж ажилласан байна. 2022 онд 96, 2023 онд 81, 2024 онд 43 байгууллагад шийдвэр хүргүүлсэн байгаагаас харахад зөрчил гаргасан байгууллагын тоо жилээс жилд буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан **сайн жишээнээс** дурдвал: *Тухайлбал:*

- Хуулийн 5 дугаар зүйл “Тэргүүн дэд, дэд, орлогч дарга” буюу 5.2-т “Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно” гэсэн заалтын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Б/32 дугаар захирамжаар Засаг даргын 1 орлогчийг, аймгийн Засаг даргын тамгын даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/144, Б/145 дугаар тушаалаар 2 зөвлөхийг ажлаас нь чөлөөлж цалингийн зардлын хэмнэлтийг бий болгож, чиг үүргийн давхардлыг арилгасан байна.
- Хуулийн 6 дугаар зүйл “Тээврийн хэрэгсэл” буюу 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажилласны дүнд орон нутгийн төсөвт байгууллагуудад бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болсон байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулиар байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналтыг хэрэгжүүлэн ажилласнаар зөрчил жилээс жилд буурсан эерэг үзүүлэлттэй байна.



- ✚ Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем **erp.e-mongolia.mn** болон албан бичиг солилцооны дундын систем **docx.gov.mn**, төрийн байгууллагын үйл ажиллагаа, хяналт, удирдлагын цогц систем **able.mn** зэрэг онлайн систем, мөн тоон гарын үсэг ашиглан төрийн байгууллагууд албан бичиг боловсруулах, илгээх, солилцох үйл ажиллагааг зохион байгуулснаар бичиг хэргийн зардал хэмнэгдсэн байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-12 дугаар зүйлийн заалтуудыг шалгадагч байгууллагууд бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна
- ✓ Байгууллагууд хэмнэлтийн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч хуулийн 15.1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна
- ✓ Хуулийн 13 дугаар зүйлд заасан “Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ”-ний 13.3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна
- ✓ Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүй байна
- ✓ Хуульд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна
- ✓ Хуулийг мөрдөж ажилласнаар 7,401,579.2 мянган төгрөгийг хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн байна
- ✓ Шилэн дансны мэдээлэл байршуулалт 93.5 хувьтай байна

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

БАЙГУУЛЛАГУУД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

Аудитаар нийт 203,316.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 8,246.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 24 зөвлөмж, 195,070.0 мянган төгрөгийн асуудлыг хууль хяналтын байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын талаар дурдвал:

Аудитын явцад аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын багш нарт 2024 онд Боловсролын ерөнхий газар, Багшийн хөгжлийн үндэсний төвөөс зорилтот болон сонголтот сургалтыг зохион байгуулаагүйгээс хэмнэгдсэн үлдэгдэл 195,070.0 мянган төгрөгийг аймгийн нэр бүхий 2 төрийн бус байгууллага руу шилжүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ. Эдгээр төрийн бус байгууллагууд нь жилийн батлагдсан төлөвлөгөөгүй, албан ёсны сургагч багшгүй, нэг төрийн бус байгууллага нь 2024 оны 12 сард 04-нд шинээр байгуулагдсан бөгөөд удирдах зөвлөлийн гишүүдийн 3 нь цэцэрлэгийн багш, 2 нь аймгийн Боловсролын газрын албан хаагч байна. Мөн тус төрийн бус байгууллагуудын сургагч багшаар ажиллах зөвшөөрлийг аймгийн Боловсролын газрын дарга олгож, сургалт хариуцсан хэлтсийн дарга болон нэр бүхий албан хаагчид нь зохион



байгуулалттайгаар төрийн бус байгууллагын нэрээр халхавч хийн сургалт хийж төлбөр авсан нь албан тушаалаа хэтрүүлэн өөрсдөд болон бусдад ашигтай нөхцөлийг бий болгож, төсвийг хохироосон байж болзошгүй асуудлыг холбогдох хууль хяналтын байгууллага болон Боловсролын яаманд шилжүүлэн шалгуулахаар ҮАГ-т уламжлалаа.

УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр худалдан авч буй барааны жагсаалтад шаардлагатай тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бараа материал байдаггүй, худалдан авах бараа, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх хүсэлтийг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлдэг боловч тухай бүр холбогдох бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт оруулдаггүй, цахим дэлгүүрийн барааны үнэ зах зээлийн үнээс өндөр, материалын хувьд чанар стандартын шаардлага хангадаггүй зэрэг шалтгааны улмаас төсвийн байгууллагууд хуулийн 14 дүгээр зүйл “Цахим худалдан авалт”-тай холбоотой заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байгаа тухай тайлбарыг ирүүлээд байна.

Иймд хуулийн дээрх заалтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд төсвийн байгууллагуудаас хүргүүлж байгаа саналыг хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээ авахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж шийдвэрлүүлэх саналыг хүргүүлж байна.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан тохиолдолд хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг нарийвчлан тусгах.

----- ooOoo -----



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч ажиллахыг зөвлөж байна.

АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ НАРТ:

- ✚ Багшийн хөгжлийн зардлыг Боловсролын сайдын 2024 оны А/279 дүгээр тушаалаар баталсан “Багшийн хөгжлийн зардлын санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ын дагуу үр дүнтэй, зориулалтын дагуу зарцуулахад анхаарч, хяналт тавьж ажиллах.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ :



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2025.05.12 № 02/659
танай 2025.05.09-ны № 281 -т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно.

ОРЛОГЧ



Ч.БАТНАЙРАМДАЛ

Аудитор Р.Цэнхүүлсүр
Амурсов 12/5

652500500306



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ :



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 4123

Эрдэнэбулган сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Эрсдэлийн удирдлагын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт хүргүүлэхийг ахлах аудитор (П.Цэцэгдулам)-д үүрэг болгосугай.

5.Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (П.Цэцэгдулам), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

T. Baygalmaa

Т.БАЙГАЛМАА



Дарга, тэргүүлэх аудиторын 2025.05.09-ны
05-сарын 12-өдрийн 112 дугаар
тушаалын хавсралт

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д
хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Хаана	Тоо	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Шийдвэр	Шийдвэрийн огноо, дугаар	Байгууллага албан тушаал
1.	Аймгийн Ерөнхий боловсролын сургууль	24	-	Зөвлөмж	2025.05.09 №88-111	Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт
2.	Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль	1	8,246,300	Албан шаардлага	2025.05.09 399/A0371093	Жаргалант сумын сургуулийн захирал
Нийт дүн		25	8,246,300			